

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/15/СТА-ОНА

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2022 он

Тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: “Пийк Ом Аудит” ХХК
Утас: 99862066 Цахим хаяг: peakomaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ААН	Аж Ахуйн Нэгж
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	Error! Bookmark not defined.
2.2 Аудит хийсэн орлого үр дүнгийн тайлан	Error! Bookmark not defined.
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	
3.Аудитын тайлан	9
3.1. Ерөнхий зүйл.....	Error! Bookmark not defined.
3.2 Дотоод хяналт.....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	
3.4 Материаллаг байдал.....	
4. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	
4.4 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	
7.Дараагийн аудитаар анхаарах асуудал	
8. Аудитын илрүүлэлт	
8.1 Залруулсан алдаа.....	
8.2 Төлбөрийн акт.....	
8.3 Албан шаардлага.....	
8.4 Зөвлөмж.....	
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	



“ТӨГӨЛДӨР ЕРӨӨ” ОНӨААТҮГ-
ЫН ДАРГА Ц. УРТНАСАН ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум

Цагаан Эрэг II баг

Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040

E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.15 № СЭА-2022/15-НА-СТА-ОНА
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал:

1. Нягтлан бодогч болон эд хариуцагч нярав зэрэг ажилтангүй, хөрөнгийн орлого, зарлагын хөдөлгөөнийг дарга Ц.Уртнасан ганцаар гүйцэтгэж, хөрөнгийг захиран зарцуулснаар хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтөд бүртгэлээр тавих хяналт алдагдсан,

СЭА-2022/15-НА-СТА-ОНА

018020365

2. Нягтлан бодох бүртгэлийн журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөөгүй буюу нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг холбогдох дарааллын дагуу гүйцэтгээгүй,
3. Бэлэн бусаар гүйцэтгэсэн 28,734.0 мянган төгрөгийн гүйлгээ нь төлбөрийн даалгавар, зарлагын хуулгагүй,
4. Дарга Ц.Уртнасангийн хувийн харилцах дансанд 14,530.0 мянган төгрөгийг шилжүүлж, ажлын хөлс болон бараа материалын төлбөрийг бэлнээр гүйцэтгэсэн боловч мөнгө хүлээн авсан хүний гарын үсгээр баталгаажаагүй,
5. Бэлтгэн нийлүүлэгч байгууллагын зарлагын падан, баримт нь тамга тэмдгээр баталгаажаагүй буюу хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар 3,324.5 мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж бүртгэл тайланд тусгасан байна.

Дээрх зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.3.1: Анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2: Журналд бичих, 14.3.3: Дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4: Ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5: Санхүүгийн тайлан гаргах”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	599,267.00	9,104,480.09
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	599,267.00	8,488,997.22
1.1.4	Ажиллагсадтай холбоотой авлага		615,482.87
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	599,267.00	9,104,480.09
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	0.00	0.00
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	599,267.00	9,104,480.09
2.1	Өр төлбөр	76,720.00	806,246.11
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	76,720.00	806,246.11
2.1.1.1	ААНОАТ өглөг		78,542.29
2.1.1.3	ХХОАТ өглөг		650,983.82
2.1.1.4	Байгууллагад төлөх өглөг	76,720.00	76,720.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	76,720.00	806,246.11
2.2	Өр төлбөрийн нийт дүн	76,720.00	806,246.11
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.1	Өмч:-төрийн		
2.3.2	хувийн		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	522,547.00	8,298,233.98
	Өмнөх үеийн үр дүн	1,534,222.00	522,547.00
	Тайлант үеийн үр дүн	-1,011,675.00	7,775,686.98
2.3.11	Эздийн өмчийн дүн	522,547.00	8,298,233.98
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	599,267.00	9,104,480.09

2.2 Аудит хийсэн орлого үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)		2,242,700.05
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг(алдагдал)	0.00	2,242,700.05
8	Бусад орлого		79,178,423.70
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,011,675.00	73,566,894.48
11	Санхүүгийн зардал		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-1,011,675.00	7,854,229.27
19	Орлогын татварын зардал		78,542.29
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-1,011,675.00	7,775,686.98
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-1,011,675.00	7,775,686.98
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
19	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
20	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Нэмж төлөгдсөн капитал	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл			1,534,222.00	1,534,222.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
Залруулсан үлдэгдэл				
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			-1,011,675.00	-1,011,675.00
Өмчид гарсан өөрчлөлт				

Зарласан ногдол ашиг				
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл			522,547.00	522,547.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
Залруулсан үлдэгдэл				
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			7,775,686.98	7,775,686.98
Зарласан ногдол ашиг				
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл			8,298,233.98	8,298,233.98

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	81,421,123.75
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		2,242,700.05
1.1.2	Бусад мөнгөн орлого		79,178,423.70
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,205,952.00	73,531,393.53
1.2.1	Ажиллагчдад төлсөн	922,464.00	9,674,398.88
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	68,618.00	2,658,653.74
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн		45,330,650.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн		
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	121,200.00	15,138,610.91
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	67,370.00	
1.2.8	Бусад мөнгөн зарлага	26,300.00	729,080.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,205,952.00)	7,889,730.22
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,205,952.00	(7,889,730.22)

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,805,219.00	599,267.00
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	599,267.00	8,488,997.22

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
2	Нийт орлого	м/төг			81,421.1	(81,421.1)	
	Үүнээс: Цэвэр борлуулалт	м/төг			2,242.7	2,242.7	
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	м/төг			79,178.4	79,178.4	
3	Нийт зардал	м/төг	1,205.9		73,645.4	(73,645.4)	
	Үүнээс:	м/төг			62,556.1	(62,556.1)	
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг						
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	м/төг	1,205.9		11,089.3	(11,089.3)	
	в) Хөрөнгө оруулалт их засвар	м/төг					
4	Цэвэр ашиг, алдагдал	м/төг	(1,205.9)		7,775.7	(7,775.7)	

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Сумын ИТХ-ын 2013 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 16 дугаар тогтоолд 2021 оны 34 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулж тус газрын дүрмийг баталсан бөгөөд үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хэвээр баталжээ.

“Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ нь худалдааны төв, ахуйн үйлчилгээ, халуун усны тохижилт, түүний орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг хариуцан гүйцэтгэх, хяналт тавих, сум, тосгоны төв дэх нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг, түүний засвар үйлчилгээг хариуцан гүйцэтгэх, авто зам болон явган хүний зам, нийтийн зам талбайг барьж байгуулах, засвар үйлчилгээг хариуцах, сумын төвд гүний цэвэр усны худаг гаргах, ахуйн хог хаягдлыг тээвэрлэх, хогийн цэгийг байгуулах, сум, тосгоны нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт, модны захыг түшиглэн мод, модон материалын

үйлдвэрлэл, барилгын засвар үйлчилгээг хариуцан ажиллах гэсэн үндсэн үүрэгтэй ажиллаж байна.

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал бөгөөд 100 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ нь сумын ИТХ-ын 2013 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 16 дугаар тогтоолоор байгуулагдсан байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд “Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх” 18 дугаар зүйлийн 18.1.3 ж-д “Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сумын ИТХТ-ийн 2021 оны 34 тоот тогтоолын 1-р хавсралтаар батлагдсан “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ-ын дүрмийг шинэчлэн баталсан байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	599.3	8,489.0	7,889.7
Авлага		615.5	615.5
Нийт хөрөнгө	599.3	9,104.5	8,505.2
Өр төлбөр	76.7	806.2	729.5
Хуримтлагдсан ашиг	522.5	8,298.2	7,775.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө, өмчийн дүн	599.3	9,104.5	8,505.2

ХААН банк дахь харилцах данс нь жилийн эцэст 8,489.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын явцад цалингийн авлагыг дутуу бүртгэснийг илрүүлж санхүүгийн тайланд залруулга хийснээс 615.5 мянган төгрөгийн авлага үүссэн байна.

Богино хугацаат өр төлбөр данс нь 806.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд урьд оны тодорхойгүй 76.7 мянган төгрөгийн, ХХОАТ-ын 650.9 мянган төгрөгийн, ААНӨТ-ын 78.6 мянган төгрөгийн өр төлбөр эзэлж байна. Өр төлбөр дансны үлдэгдэл 729.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд ажиллагсдын цалингаас суутгасан ХХОАТ-ын 650.9 мянган төгрөгийг зохих дансанд төвлөрүүлээгүй, тайлант онд ашигтай ажилласнаас 78.6 мянган төгрөгийн ААНӨТ-ын өглөг үүссэн зэргээс шалтгаалсан байна.

3.4 Техник эдийн засгийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ нь 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүйгээр үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээс 60,805.6 мянган төгрөг төвлөрүүлж гудамжны гэрэлтүүлгийг туузан гэрлээр ороох ажлыг 10,000.0 мянган төгрөгөөр, хогийн цэг цэвэрлэж хашаажуулах ажлыг 14,805.6 мянган төгрөгөөр, хуучин тоглоомын талбай засварлах ажлыг 16,000.0 мянган төгрөгөөр, багийн төвийн байрны халаалтын шугам тавих ажлыг 20,000.0 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэжээ.

Сумын ЗДТГ-ын батлагдсан төсвөөс гэрэлтүүлгийн засвар үйлчилгээнд 9,753.2 мянган төгрөг, сумын төвийн хог хаягдлыг ачих, цэвэрлэх ажилд 8,619.6 мянган төгрөгийг санхүүжүүлж гэрээт ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

“Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ нь иргэд, аж ахуйн нэгжийн хог хаягдал ачих, бохир соруулах зэрэг үйл ажиллагаанаас 2,242.7 мянган төгрөгийг бүрдүүлж ажилласан байна.

Гүйцэтгэлээр 81,421.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 73,675.4 мянган төгрөгийн зардал гарган, 7,775.7 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн аймгийн Засаг даргын 2021 оны А/58 тоот захирамжаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн жишиг заавар”-ыг мөрдөж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу 2022 оны 2 дугаар сарын 15-наас 2022 оны 3 дугаар сарын 13-ны хооронд “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар хэрэгжүүлсэн.

“Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг “Пийк Ом Аудит” ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. Дотоод хяналт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж дүгнэж байна. Үүнд:

- 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж зохих байгууллагаар батлуулаагүй,
- Үйлдвэрийн газрын захиргааны бүтэц, орон тоо, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоогоогүй, хөдөлмөрийн дотоод журмыг боловсруулаагүй,
- Үйлдвэрийн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй байна.

“Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ нь ТЕЗ буюу Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг бүртгэлийн үйл ажиллагаанд баримтлахаар зохицуулагдсан боловч мөрдөөгүй байна.

Иймд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн байгууллагын өөрийн онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөх шаардлагатай байна.

“Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ-ын хувьд дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан байхгүй байна. Тайлант жилийн хугацаанд хяналт, шалгалт хийгээгүй байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс

үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ-ын ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн зардал 73,645.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1,472.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант хугацаанд “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ нь мэдээлбэл зохих 18 төрлийн 148 мэдээлэл байршуулахаас 143 мэдээллийг огт мэдээлээгүй, 4 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Үүнд:

- Төсөв гүйцэтгэлтэй холбоотой 48 мэдээллээс 1-ийг хугацаанд нь мэдээлж, 1 мэдээллийг хугацаа хоцроож, 46 мэдээллийг огт мэдээлээгүй,
- Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 39 мэдээллийг огт мэдээлээгүй,
- Бусад 68 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож, 65 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж хүргүүлсэн бөгөөд хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1		1				100.0
Нийт дүн	1		1				100.0

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

“Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ-ын дарга, жолооч нарыг төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээгээр цалинжуулсан байна.

Энэ нь ОНӨААТҮГ-ын хувьд өөрөө өөрийгөө санхүүжүүлэгч байгууллагын хувьд дүрэмд заасны дагуу ИТХ-аар цалин хөлс, нэмэгдлийн хэмжээг тогтоох заалттай нийцэхгүй байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 147,521.4 мянган төгрөгийн 12 алдаа зөрчил илэрснээс 100,932.9 мянган төгрөгийн 6 алдааг залруулж, 46,588.5 мянган төгрөгийн зөрчилд 4 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2 зөрчилд зөвлөмж өглөө.

8.1 Залруулсан алдаа:

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 100,932.9 мянган төгрөгийн 6 алдааг залрууллаа. Үүнд:

1. Борлуулалтын орлогыг буруу ангилж бүртгэсэн 77,199.7 мянган төгрөг,
2. ААНӨТ-ын зардлыг дутуу бүртгэсэн 5.0 мянган төгрөг,
3. Тайлант үеийн үр дүнг дутуу илэрхийлсэн 494.0 мянган төгрөг,
4. Үйл ажиллагааны зардлыг буруу хуримтлуулан бүртгэсэн 22,657.6 мянган төгрөг,
5. Өглөгийн эхний үлдэгдлийг орхигдуулсан 76.7 мянган төгрөг
6. Ажиллагсадтай холбоотой цалингийн авлагыг дутуу бүртгэсэн 499.9 мянган төгрөг,

8.2 Албан шаардлага

1. Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, сумын ИТХ, Засаг даргаар батлуулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “*үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах*” гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг гарган сумын Засаг даргаар батлуулж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ нь нягтлан бодогч, нярав эд хариуцагч байхгүйгээс хөрөнгийн орлого, зарлагын хөдөлгөөнийг дарга Ц.Уртнасан ганцаар гардан гүйцэтгэж, хөрөнгийг захиран зарцуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1 дэх *“Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”*, 2 дахь *“Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна”* гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн хөтлөх мэргэжлийн нягтлан бодогч, эд хариуцагчийг томилон ажиллуулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант онд бэлэн бусаар төлбөр гүйцэтгэсэн 28,734.0 мянган төгрөгийн гүйлгээ нь төлбөрийн даалгавар, зарлагын хуулгагүй, дарга Ц.Уртнасангийн хувийн харилцах дансанд 14,530.0 мянган төгрөгийг шилжүүлж ажлын хөлс болон бараа материалын төлбөрийг бэлнээр гүйцэтгэсэн боловч мөнгө хүлээн авсан хүний гарын үсэггүй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагын зарлагын падан баримт нь тамга тэмдгээр баталгаажаагүй 3,324.5 мянган төгрөгийн зэрэг нийт 46,588.5 мянган төгрөгийн ажил гүйлгээ нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдэлгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”*, 13.7 дахь *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгахыг хориглоно”* гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүчин төгөлдөр анхан шатны баримтад үндэслэн төлбөр тооцоог гүйцэтгэх, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ТЕЗ буюу Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцээгүй бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын өөрийн онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан, мөрдөх.

2. Хөрөнгө нөөцийн бүртгэлтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт:Сумын ИТХ-ын 2013 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 16 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан нийтийн эзэмшлийн хөрөнгүүдийг ОНӨААТҮГ-ын хөрөнгөнд бүртгэж авах талаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: ИТХ-ын шийдвэрийг дахин хянан үзэж зохих байгууллагад хандаж асуудлыг шийдвэрлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
						Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар													
1	Төгөлдөр Ерөө ОНАӨӨТҮГ	СЭА-2022/15/СТ А-ОНА	Борлуулалтын орлогыг буруу ангилж бүртгэсэн	1	77,199.7	1	77,199.7						
2			ААНОАТ-ыг дутуу бүртгэсэн	1	5.0	1	5.0						
3			Тайлант үеийн үр дүнг дутуу идэрхийлсэн	1	494.0	1	494.0						
4			Үйл ажиллагааны зардлыг буруу хуримтлуулан бүртгэсэн	1	22,657.6	1	22,657.6						
5			Өглөгийн эхний үлдэгдлийг орхигдуулсан	1	76.7	1	76.7						
6			Цалингийн авлагыг дутуу бүртгэсэн	1	499.9	1	499.9						
7			2021 оны үйлдвэрлэлийн болон санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй. байна	1					1				
8			Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөөгүй байна.	1								1	
9			ҮГ-ын дарга хөрөнгийг ганцаар захиран зарцуулсан	1					1				
10			Анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй	1	46,588.5				1	46,588.5			
11			Сумын ИТХ-ын 2013 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 16 дугаар тогтоолын 2-р хавсралтаар	1									1
11	Дүн			11	147,521.4	6	100,932.9			3	46,588.5	2	
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал													
1	Төгөлдөр Ерөө ОНАӨӨТҮГ	СЭА-2022/15/СТ А-ОНА	Шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд мэдээлэл оруулаагүй	1						1			
1	Дүн			1						1			
12	Нийт дүн			12	147521.4	6	100932.9	0	0	4	46588.5	2	0